

“Нэйшнл лайф даатгал” ХХК-д урт хугацааны
даатгалын зарим хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 20.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Нэйшнл лайф даатгал” ХХК-д “хуримтлалын” болон “хугацаат амьдралын” даатгалын хэлбэрүүдээр урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2.“Нэйшнл лайф даатгал” ХХК-д энэ тогтоолын 1-д зааснаас бусад даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхгүй болохыг анхааруулсугай.

3.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар (С.Ганболд), “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолоор зөвшөөрөл олгосон даатгалын хэлбэрүүдийг нэмж бүртгэхийг Тамгын газар (Ж.Жадамбаа)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН